



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 17 өдөр

Дугаар А/305

Булган

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 47.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Ургамалан бүрхэцийн зураг авалт хийж ургац болон даацыг тодорхойлох мониторинг хийх ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны

дарга: - Д.Буманбаяр Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд: - Ц.Батжаргал Орон нутгийн өмчийн газрын дарга

- М.Мөнхбат Статистикийн хэлтсийн дарга

Иргэний төлөөлөл: - Ц.Даваадорж Булган сумын иргэн

Нарийн бичгийн дарга: - Б.Баярцэнгэл Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

2. Тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хороо /Д.Буманбаяр/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА *Д.Баяр* З.БАТЗОРИГ

